

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Татварын хэлтсийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/176-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn www.open.audit.mn Сүхбаатар сум 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитор: О.Анхбаяр Утас: 7036-2442 Цахим хаяг: ankhbayaro@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.АУДИТЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	10
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар.....	16
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
5.1 Зөвлөмж	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТБОНӨХБАУХАТ	Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай
ТЕГ	Татварын ерөнхий газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ТАТВАРЫН
ХЭЛТСИЙН ДАРГА Ц.ЛХАГВАДОРЖ
ТАНАА

Сэлэнгэ аймгийн Татварын хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Татварын хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Татварын хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосноос голлон шалтгаалж тус газрын 2023 оны нийт зардал өмнөх оноос 64.2 хувиар нэмэгдсэн байна.

ТӨБЗГ-ын даргын 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 233 дугаар тогтоолоор 1,324,298.6 мянган төгрөгийн өртөгтэй Татварын хэлтсийн барилга, байгууламжийг ашиглалтад хүлээн авч бүртгэл, тайланд тусгасан байна.

Аудитын гол асуудал

ТЕГ-аас хийгдсэн төсвийн зохицуулалтаар хөрөнгө битүүмжлэх лац худалдан авах 5,550.0 мянган төгрөгийн төсвийг бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил,

үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд тусгаж, Нода ХХК-иас нэг бүрийг нь 0.3-36.0 мянган төгрөгөөр тооцон 1.5 мянган ширхэг, 5,434.0 мянган төгрөгийн лац худалдан авсан байна.

Бэлтгэн нийлүүлсэн лацыг тайлант онд нэг ширхгийг ч зарцуулалгүйгээр бүгд үлдэгдлээр тайлагнагдсан бөгөөд шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр нөөцлөн, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан нь төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах зарчмыг алдагдуулж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх *“Төсвийн байгууллага ...-д дараах зүйлийг хориглоно.”* 15.1.6 дахь *“... шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх”* гэсэн заалтыг зөрчсөн байна.

Бусад асуудлын хэсэг

Сэлэнгэ аймгийн Татварын хэлтэс нь тайлант онд “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд 45 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 91.9 хувийн биелэлттэй тайлагнагдсан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	42,548,634.58	47,207,735.20
35	БАРАА МАТЕРИАЛ	42,548,634.58	47,207,735.20
35400	Хангамжийн материал	42,548,634.58	47,207,735.20
35410	Бичиг хэргийн материал	2,371,294.54	1,613,659.57
35420	Аж ахуйн материал	25,786,746.77	29,140,954.18
35440	Түлш, шатах тослох материал	502,830.00	242,690.00
35470	Бусад хангамжийн материал	13,887,763.27	16,210,431.45
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	231,006,839.99	1,477,619,657.04
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	231,006,839.99	1,477,619,657.04
39200	Биет хөрөнгө	218,100,839.99	1,463,729,657.04
39201	Барилга, байгууламж, орон сууц	52,866,836.17	1,377,165,454.17
39202	Хуримтлагдсан элэгдэл	-37,176,734.35	-51,630,980.95
39203	Авто-тээврийн хэрэгсэл	113,300,000.00	113,300,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-47,914,738.92	-66,780,844.32
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	321,602,589.24	298,142,094.74
39206	Хуримтлагдсан элэгдэл	-197,237,197.48	-217,045,617.38
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	33,603,840.10	28,693,840.10
39208	Хуримтлагдсан элэгдэл	-20,943,754.77	-18,114,289.32
39300	Биет бус хөрөнгө	12,906,000.00	13,890,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	12,906,000.00	13,890,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	273,555,474.57	1,524,827,392.24
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	273,555,474.57	1,524,827,392.24
51	Засгийн газрын хувь оролцоо	273,555,474.57	1,524,827,392.24
51100	Засгийн газрын оруулсан капитал	369,861,425.84	369,861,425.84
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	369,861,425.84	369,861,425.84
51200	Хуримтлагдсан үр дүн	-96,305,951.27	1,154,965,966.40
51210	Өмнөх үеийн үр дүн	-39,026,113.92	-96,305,951.27
51220	Тайлант үеийн үр дүн	-57,279,837.35	1,251,271,917.67
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	273,555,474.57	1,524,827,392.24

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,178,682,902.01	3,178,160,911.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	24,588,602.01	1,335,452,511.20
120	Нийтлэг татварын бус орлого	18,888,602.01	1,335,452,511.20
120009	Бусад орлого	35,000.00	35,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	9,639,722.63	1,333,720,418.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	9,213,879.38	1,697,093.20
121	Хөрөнгийн орлого	5,700,000.00	0.00
121001	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	5,700,000.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,154,094,300.00	1,842,708,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,148,094,300.00	1,832,708,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,148,094,300.00	1,832,708,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,000,000.00	10,000,000.00

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,000,000.00	10,000,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,235,893,109.36	1,926,878,433.53
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,235,893,109.36	1,926,878,433.53
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,025,154,916.45	1,614,993,257.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	701,668,533.52	1,199,553,192.20
210101	Үндсэн цалин	476,805,018.74	677,550,635.40
210102	Нэмэгдэл	83,864,183.00	228,762,240.05
210103	Унаа хоолны хөнгөлөлт	65,686,333.88	68,873,006.90
210104	Урамшуулал	75,312,997.90	224,367,309.85
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	89,131,520.38	152,912,553.00
210201	Тэтгэврийн даатгал	61,095,279.37	104,978,173.60
210202	Тэтгэмжийн даатгал	7,187,679.90	12,368,814.69
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,629,183.96	9,635,451.77
210204	Ажилгүйдлийн даатгал	1,381,979.97	2,357,282.99
210205	Эрүүл мэндийн даатгал	13,837,397.18	23,572,829.95
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,091,361.51	26,900,058.39
210301	Гэрэл, цахилгаан	3,868,480.51	5,520,454.43
210302	Түлш, халаалт	15,677,397.00	18,792,265.96
210303	Цэвэр, бохир ус	3,545,484.00	2,587,338.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,422,115.48	25,969,801.63
210401	Бичиг хэрэг	3,692,757.80	6,014,700.00
210402	Тээвэр, шатахуун	4,311,170.00	6,260,140.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,819,367.68	4,695,698.05
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	144,000.00	160,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,454,820.00	8,839,263.58
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,470,721.00	2,922,699.00
210604	Урсгал засвар	1,470,721.00	2,922,699.00
2107	Томилолт, зочны зардал	3,185,000.00	10,311,000.00
210702	Дотоод албан томилолт	3,185,000.00	10,311,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	93,086,106.00	92,291,132.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	92,443,384.00	91,724,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	420,200.00	420,180.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	148,700.00	112,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	22,000.00
210807	Газрын төлбөр	12,552.00	12,552.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	17,270.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	96,099,558.56	104,132,820.95
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,735,000.00	10,050,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,209,210.00	6,975,220.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	78,155,348.56	87,107,600.95
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	210,738,192.91	311,885,176.36
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,934,900.00	56,397,736.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,574,900.00	47,551,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,360,000.00	8,846,736.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	187,803,292.91	255,487,440.36
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	187,803,292.91	255,487,440.36
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-57,210,207.35	1,251,282,477.67

V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	69,630.00	10,560.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	69,630.00	10,560.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-57,279,837.35	1,251,271,917.67

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,159,829,300.00	1,842,743,400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,735,000.00	35,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	35,000.00	35,000.00
120009	Бусад орлого	35,000.00	35,000.00
121	Хөрөнгийн орлого	5,700,000.00	0.00
121001	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	5,700,000.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,154,094,300.00	1,842,708,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,148,094,300.00	1,832,708,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,148,094,300.00	1,832,708,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,000,000.00	10,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,000,000.00	10,000,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,159,829,300.00	1,842,743,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,159,829,300.00	1,842,743,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	949,091,107.09	1,530,858,223.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	701,668,533.52	1,199,553,192.20
210101	Үндсэн цалин	476,805,018.74	677,550,635.40
210102	Нэмэгдэл	83,864,183.00	228,762,240.05
210103	Унаа хоолны хөнгөлөлт	65,686,333.88	68,873,006.90
210104	Урамшуулал	75,312,997.90	224,367,309.85
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	89,131,520.38	152,912,553.00
210201	Тэтгэврийн даатгал	61,095,279.37	104,978,173.60
210202	Тэтгэмжийн даатгал	7,187,679.90	12,368,814.69
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,629,183.96	9,635,451.77
210204	Ажилгүйдлийн даатгал	1,381,979.97	2,357,282.99
210205	Эрүүл мэндийн даатгал	13,837,397.18	23,572,829.95
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,091,361.51	26,900,058.39
210301	Гэрэл, цахилгаан	3,868,480.51	5,520,454.43
210302	Түлш, халаалт	15,677,397.00	18,792,265.96
210303	Цэвэр, бохир ус	3,545,484.00	2,587,338.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,995,911.69	21,032,968.05
210401	Бичиг хэрэг	4,575,762.00	4,675,400.00
210402	Тээвэр, шатахуун	3,974,000.00	6,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,894,223.69	4,695,698.05
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	144,000.00	160,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,407,926.00	5,501,870.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,802,500.00	5,398,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	2,900,000.00
210604	Урсгал засвар	1,802,500.00	2,498,100.00
2107	Томилолт, зочны зардал	3,185,000.00	10,311,000.00
210702	Дотоод албан томилолт	3,185,000.00	10,311,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	93,013,779.99	97,725,132.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	92,388,327.99	97,158,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	420,200.00	420,180.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	148,700.00	112,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	22,000.00
210807	Газрын төлбөр	12,552.00	12,552.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,202,500.00	17,025,220.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,735,000.00	10,050,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,467,500.00	6,975,220.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	210,738,192.91	311,885,176.36
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,934,900.00	56,397,736.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,574,900.00	47,551,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,360,000.00	8,846,736.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	187,803,292.91	255,487,440.36
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	187,803,292.91	255,487,440.36

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	369,861,425.84	0.00	-39,026,113.92	330,835,311.92
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	369,861,425.84	0.00	-39,026,113.92	330,835,311.92
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-57,279,837.35	-57,279,837.35
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	369,861,425.84	0.00	-96,305,951.27	273,555,474.57
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	369,861,425.84	0.00	-96,305,951.27	273,555,474.57
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	369,861,425.84	0.00	-96,305,951.27	273,555,474.57
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,251,271,917.67	1,251,271,917.67
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	369,861,425.84	0.00	1,154,965,966.40	1,524,827,392.24

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү /хэтрэлт, хэмнэлт/	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,832,708,400.00	1,577,220,959.64	-255,487,440.36	86.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,832,708,400.00	1,577,220,959.64	-255,487,440.36	86.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,775,210,500.00	1,520,823,223.64	-254,387,276.36	85.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,423,723,000.00	1,199,553,192.20	-224,169,807.80	84.25
210101	Үндсэн цалин	680,090,300.00	677,550,635.40	-2,539,664.60	99.63
210102	Нэмэгдэл	286,834,100.00	228,762,240.05	-58,071,859.95	79.75
210103	Унаа хоолны хөнгөлөлт	86,871,400.00	68,873,006.90	-17,998,393.10	79.28

210104	Урамшуулал	369,927,200.00	224,367,309.85	-145,559,890.15	60.65
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	177,965,500.00	152,912,553.00	-25,052,947.00	85.92
210201	Тэтгэврийн даатгал	121,016,500.00	104,978,173.60	-16,038,326.40	86.75
210202	Тэтгэмжийн даатгал	14,237,300.00	12,368,814.69	-1,868,485.31	86.88
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,389,800.00	9,635,451.77	-1,754,348.23	84.60
210204	Ажилгүйдлийн даатгал	2,847,500.00	2,357,282.99	-490,217.01	82.78
210205	Эрүүл мэндийн даатгал	28,474,400.00	23,572,829.95	-4,901,570.05	82.79
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,026,800.00	26,900,058.39	-5,126,741.61	83.99
210301	Гэрэл, цахилгаан	6,240,000.00	5,520,454.43	-719,545.57	88.47
210302	Түлш, халаалт	21,786,800.00	18,792,265.96	-2,994,534.04	86.26
210303	Цэвэр, бохир ус	4,000,000.00	2,587,338.00	-1,412,662.00	64.68
2104	Хангамж, бараа материалын зардал	21,000,000.00	20,997,968.05	-2,031.95	99.99
210401	Бичиг хэрэг	4,040,000.00	4,640,400.00	600,400.00	114.86
210402	Тээвэр, шатахуун	6,000,000.00	6,000,000.00	0.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,600,000.00	4,695,698.05	-904,301.95	83.85
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	360,000.00	160,000.00	-200,000.00	44.44
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,000,000.00	5,501,870.00	501,870.00	110.04
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,400,000.00	5,398,100.00	-1,900.00	99.96
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,900,000.00	2,900,000.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	2,500,000.00	2,498,100.00	-1,900.00	99.92
2107	Томилолт, зочны зардал	10,311,000.00	10,311,000.00	0.00	100.00
210702	Дотоод албан томилолт	10,311,000.00	10,311,000.00	0.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	97,729,200.00	97,725,132.00	-4,068.00	100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	97,162,000.00	97,158,000.00	-4,000.00	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	420,200.00	420,180.00	-20.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	112,400.00	112,400.00	0.00	100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	22,000.00	0.00	100.00
210807	Газрын төлбөр	12,600.00	12,552.00	-48.00	99.62
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,055,000.00	7,025,220.00	-29,780.00	99.58
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	55,000.00	50,000.00	-5,000.00	90.91
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,000,000.00	6,975,220.00	-24,780.00	99.65
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	57,497,900.00	56,397,736.00	-1,100,164.00	98.09
2132	Бусад урсгал шилжүүлэг	57,497,900.00	56,397,736.00	-1,100,164.00	98.09
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	47,551,100.00	47,551,000.00	-100.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,946,800.00	8,846,736.00	-1,100,064.00	88.94

III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,832,708,400.00	1,577,220,959.64	-255,487,440.36	86.06
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,832,708,400.00	1,577,220,959.64	-255,487,440.36	86.06
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,832,708,400.00	1,577,220,959.64	-255,487,440.36	86.06

2.5 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

			/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл	
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,000,000.00	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,000,000.00	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,000,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,000,000.00	
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,000,000.00	
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	10,000,000.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,000,000.00	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,000,000.00	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Татварын хэлтэс /Татварын хэлтэс/ нь 2023 оныг “Цахим татварын алба” болгох зорилтын хүрээнд “Татварын хууль тогтоомж даган мөрдөлтийн эрсдэлийг удирдах, хууль тогтоомжийг сайн дураар даган мөрдөлтийг олон улсын түвшинд хүргэх, улс, орон нутгийн төсвийн татварын орлого бүрдүүлэх” гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлэн ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, татвар төлөгчийг мэдээллээр ханган зөвлөгөө өгөх, сургалт сурталчилгаа явуулах,
- Татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих,
- Улс, орон нутгийн төсвийн татварын орлого бүрдүүлэх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад 2023 оны 07 дугаар сарын 07-нд өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд өөрчлөлт орсон,
- Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 05 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дүгээр сарын 10, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,

- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн зарим албан хаагчийн цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Татварын хэлтсийн санхүүгийн үйл ажиллагаанд Татварын ерөнхий газрын “Дотоод аудит, хяналт, шинжилгээ, үнэлгээний газар”-аас сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хэрэгжүүлж байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Татварын хэлтсийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг **аккруэл** сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

ТЕГ-ын даргын 2020 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн А/156 дугаар тушаалаар баталсан “Монголын татварын албаны нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг харьяа байгууллагууд дагаж мөрдөхөөр баталсан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Татварын хэлтсийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,251,271.9 мянган төгрөгөөр буюу 5.5 дахин өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	0.00	0.00	0.00
Бараа материал	42,548.60	47,207.70	4,659.10
Үндсэн хөрөнгө	231,006.90	1,477,619.70	1,246,612.80
Нийт хөрөнгө	273,555.50	1,524,827.40	1,251,271.90
Өр төлбөр	0.00	0.00	0.00
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	273,555.50	1,524,827.40	1,251,271.90
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	273,555.50	1,524,827.40	1,251,271.90

Дээрх хүснэгтээс харахад нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данснууд байна. Үүнд:

Бараа материалын дансны үлдэгдэл 47,207.7 мянган төгрөг болж 4,659.1 мянган төгрөгөөр өссөн нь дараах хүчин зүйлүүдээс шалтгаалсан байна. Үүнд:

- Төсвийн хөрөнгөөр 31,462.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан,
- ТЕГ-аас 1,697.1 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүй хүлээн авсан,
- Үйл ажиллагаанд 28,500.1 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан гэх мэт.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,477,619.7 мянган төгрөг болж 1,246,612.8 мянган төгрөгөөр өссөн нь ТӨБЗГ-ын 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 233 дугаар тогтоолоор 1,324,298.6 мянган төгрөгийн үнэ бүхий албан конторын барилга, байгууламжийг үндсэн хөрөнгөд бүртгэснээс голлон шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,256,765.4 мянган төгрөг, нийт зарлагыг 1,256,765.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас дараах байдлаар өөрчлөн баталсан байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг **1,083.4** мянган төгрөгөөр нэмэгдүүлж,
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 6,175.7 мянган төгрөгөөр,
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 27,319.2 мянган төгрөгөөр,
- Хангамж бараа материалын зардлыг 18,922.9 мянган төгрөгөөр,
- Эд хогшил, урсгал засварын зардлыг 4,550.0 мянган төгрөгөөр,
- Томиллолт, зочны зардлыг 18,600.0 мянган төгрөгөөр,

- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 8,311.2 мянган төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 5,820.0 мянган төгрөгөөр,
- Бусад урсгал шилжүүлгийн зардлыг 91,125.6 мянган төгрөгөөр зэрэг **180,824.6** мянган төгрөгөөр бууруулж, нийт 1,077,024.2 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн жилийн дундуур батлагдсан төсвийг 755,684.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн /цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 586,685.0 мянган төгрөгөөр, НДШ-ийн зардлыг 69,573.8 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 11,400.0 мянган төгрөгөөр, томилолт, зочны зардлыг 9,711.0 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлгийн зардлыг 56,397.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн нь голлон нөлөөлсөн байна/ нийт **1,832,708.4** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлээр төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,832,708.4 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөн, гүйцэтгэлээр санхүүжилтийг бүрэн төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,577,221.0 мянган төгрөг буюу 86.1 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 254,383.3 мянган төгрөгөөр хэмнэснээс голлон шалтгаалсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,683,482.50	1,429,099.30	(254,383.30)	86.8
2	Мэдээлэл, сурталчилгааны зардал	1,500.00	1,496.00	(4.00)	98.0
3	Харуул, хамгаалалтын зардал	28,800.00	28,800.00	0.00	100.0
4	Холбооны суваг ашигласны хөлс	61,428.00	61,428.00	0.00	94.9
5	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	57,497.90	56,397.70	(1,100.20)	87.2
	Дүн	1,832,708.40	1,577,221.00	(255,487.40)	86.1

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130011401 тоот дансанд аймгийн Засаг даргын А/247 дугаар захирамжаар “Татвар төлөгчдийн өдрүүд” зохион байгуулах 5,000.0 мянган төгрөг, А/508 дугаар захирамжаар “Төвийн бүсийн сургалт, зөвлөгөөн”-д оролцох зардалд 5,000.0 зэрэг нийт 10,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг ЗДНХ-өөс авч, зориулалтын дагуу зарцуулсан байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд дараах худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

Хүснэгт 3. Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөв	Гэрээний дүн	Худалдан авах ажиллагаанд мөрдөх журам / Тендер шалгаруулалтын арга
1	Харуул хамгаалалт	28,800.0	28,800.0	Харьцуулалтын арга
	Нийт дүн	28,800.0	28,800.0	

Харуул хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх тендерт зөвхөн Шүрэн-Үндэс ХХК материал ирүүлснийг гүйцэтгэгчээр шалгаруулж, гэрээ байгуулан ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Татварын хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн зардлыг бодит хэрэгцээ шаардлага, тооцоо судалгаан дээр үндэслэж, үнэн зөв төлөвлөж, хэрэгжүүлэх зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Анхбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Татварын хэлтсийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 73 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,235,893.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу **12,358.9**

мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж дүгнэсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

ТЕГ-аас “Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах чиглэл” цахим хурлыг зохион байгуулж харьяа газруудад чиглэл өгсний дагуу дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Тайлант онд хэвлэл захиалга хийгээгүй,
- Сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, холбогдон гарах зардлыг хэмнэсэн,
- Албан хаагчдад татвар төлөгчтэй холбоо барих гар утасны зардал олголтыг зогсоосон,
- Байгууллагын цахилгааны хэрэглээнд албан хаагчдыг хэмнэлттэй байх үүрэг даалгавар өгч үр ашиггүй зардал гаргахгүй ажиллаж, өр төлбөргүй тайлагнагдсан гэх мэт.

Харин ТЕГ-аас хийгдсэн төсвийн зохицуулалтаар Нода ХХК-иас нэг бүрийг нь 0.3-36.0 мянган төгрөгөөр тооцон 1.5 мянган ширхэг, 5,434.0 мянган төгрөгийн лац худалдан авч, шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр нөөцөлсөн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага ...-д дараах зүйлийг хориглоно:” 15.1.6 дахь “... шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Татварын хэлтэс нь мэдээлбэл зохих 28 төрлийн 171 мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 123 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 100.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2		2		100.0
Нийт дүн	2		2		100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлуудыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. ТЕГ-аас хийгдсэн төсвийн зохицуулалтаар хөрөнгө битүүмжлэх лац худалдан авах 5,550.0 мянган төгрөгийн төсвийг бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардалд бус бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд тусгаснаас шалтгаалж Нода ХХК-иас нэг бүрийг нь 0.3-36.0 мянган төгрөгөөр тооцон 1.5 мянган ширхэг, 5,434.0 мянган төгрөгийн лац худалдан авч, төсвийг зориулалт бусаар, зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*” гэсэн заалтуудыг болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “*Зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврын*”-ыг тус тус зөрчсөн байна.

Бэлтгэн нийлүүлсэн лацыг тайлант онд нэг ширхгийг ч зарцуулалгүйгээр бүгд үлдэгдлээр тайлагнагдсан бөгөөд шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр нөөцлөн, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “*Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “*Төсвийн байгууллага ...-д дараах зүйлийг хориглоно:*”

15.1.6 дахь “... шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

4. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **840.0** мянган төгрөгийн зөрчил¹ илэрч 1 зөвлөмж өглөө.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Төсвийн төлөвлөлтийг бодит хэрэгцээ шаардлага, судалгаанд үндэслэн зардлын зүйл, эдийн засгийн ангиллаар нь үнэн зөв төлөвлөөгүйгээс ZOOM APP-ийн 12 сарын эрх авахад 840.0 мянган төгрөгийг шуудан холбоо, интернэтийн төлбөрийн зардлаас санхүүжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална”, 5.1.2 дахь “Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Зардлыг бодит хэрэгцээ шаардлага, тооцоо судалгаан дээр үндэслэж, үнэн зөв төлөвлөж, хэрэгжүүлэх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5² дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төсвийг бодитоор, үнэн зөв төлөвлөөгүй	1	840.0					1	840.0				
Дүн	1	840.0					1	840.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Нийт дүн									